

Ханбогд сумын Малчдын төлөөлөл болон Оюу Толгой компанийн хэлцлийн тухай мэдээлэл

Ханбогд сум

Их булаг

2013 он 8 сарын 24 өдөр

2012 оны 10 сард Ханбогд сумын малчид, “Говийн газар шороо” болон “Оюу Толгой Хяналт” төрийн бус байгааллага хамтран Дэлхийн банкны дэргэдэх Эрх зүйн хяналт, Зөвлөлгөө, Омбудсман \Эрхийг хамгаалагч\ -ийн газарт хандаж Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбогдуулан гомдол гаргасан.

Уг гомдол нь:

- 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөлөл ба гэрээний хэрэгжилт хангалтгүй
- 2011 оны нөлөөллийн нөхөх олговрын гэрээ, нөхөх олговор тогтоосон шалгуур зохисгүй
- Энэ хоёр гэрээ доорхи сөрөг нөлөөллийг зогсоох, бууруулах ажил болж чадаагүй
 - o Амжиргаа доройтох орлогын эх үүсвэр алдагдах
 - o Мал хорогдох, малын ашиг шим буурах, малын эрүүл мэнд доройтох
 - o Усны хомсдол
 - o Бэлчээр хомсдох, доройтох, тоосжилт
- Хоёр гэрээгээр тохирсон нөхөн олговор бүрэн ба зохистой хэрэгжээгүй. Үүнд:
 - o Ажлын байраар хангах
 - o Хүүхдийн сургуулийн тэтгэлэг
 - o Мөнгөн нөхөх олговор
 - o Амжиргааны түвшинг хянах, хэмжих
 - o Эрүүл мэндийн хамгаалал байхгүй
 - o Монголын нүүдлийн мал аж ахуйн соёл уламжлал алдагдах
 - o Шинэ бизнес, аж ахуй эрхлэх, мэргэжил эзэмшүүлэх, сургах
 - o Гүний хоолой
 - o Онгоцны буудал
 - o Үндэсний болон олон улсын хууль эрх зүйн зарчмууд хэрэгжихгүй
- Ундайн голын годирол өөрчлөхийг эсэргүүцсэн зэрэг асуудлыг хамарсан.
Эрх зүйн хяналтын газар дээрх гомдлыг авч хэлэлцээд өөрийн эвлрүүлэн зуучлах багийг томилон ажиллуулж байна. Тус баг Ханбогд суманд хүрэлцэн ирж дээрх Төрийн бус байгууллага, нутгийн малчид, орон нутгийн удирдлага мөн Оюу Толгой ХХК-ийн төлөөлөлтэй уулзсан ба Ханбогд сумын малчид, Говийн газар шороо болон Оюу Толгой хяналт төрийн бус байгууллага, Оюу Толгой ХХК мөн хөдлөнгийн ажиглагчдыг оролцуулсан мэдээлэл солилцох, хэлцэл хийх 4 удаагийн уулзалтыг зохион байгуулаад байна. Дээрх уулзалт хэлцлүүдэд малчдыг төлөөлөх баг “Малчдын төлөөлөл” баг тус бүрээс багийн хурлаар сонгогдон оролцож байна.

Эдгээр уулзалтын үр дүнд Малчдын төлөөллийн хүсэлтийг Оюу Толгой ХХК хүлээн зөвшөөрч шаардлагатай мэдээллийг бичгээр гаргаж өгөх, тухайлсан уулзалт зохион байгуулах, төслийн талбайд нэвтэрч газар дээр нь үзэж танилцах боломжоор хангах зэрэг дээр харилцан тохиролцсон. Үүнд:

Оюу Толгой ХХК-аас мэдээлээр хангах:

- ОТ дотор/гадна цооногуудын хэмжилтийг хамтарч хийсэн
- Гүний хоолой болон ОТ орчмын усны чанарын судалгаа хийсэн эрдэмтэн Пүрэвдорж болон олон улсын судлаачид Малчдын төлөөлөлд мэдээлэл хийх уулзалтыг ОТ зохион байгуулсан
- ОТ компанийн Байгаль орчны хэлтсийн Усны багийн судалгааны мэдээллээр хангасан
- ОТ ургамал судлаач Санжид Малчдын төлөөлөгч Бямбадорж нар Гүний хоолойн орчмын бэлчээрийн ургамлын судалгааг хамтран хийсэн

- Гүний хоолой дах шүүрч буй цооногийг хаах тухай Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын зөвшөөрөл, уг ажлын төлөвлөгөөг малчдын төлөөлөлд танилцуулсан
- Ундай голын голдиролд хэсэгчлэн тохируулга хийх төслийн инженерүүд мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулсан
- Ундай голын голдиролд хэсэгчлэн тохируулга хийх төслийн инженерингийн зургийг малчдын төлөөлөлд танилцуулсан
- Ундай голын төслийн мэдээллийг өгч, зөвшилцсөн малчдын нэрс ба тэднээс гарсан саналыг Малчдын төлөөлөлд танилцуулсан
- Уурхайн усны хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн
- ХБ-ОТ замын ТЭЗҮ-ийн талаар мэдээлэл өгсөн

Малчдын төлөөллөөс хийсэн:

- Гомдолтой малин өрхүүдийг төлөөлөн хийж буй үйл ажиллагааны талаар малчдад мэдээдлэх, санал авах
- 2011 оны Нөхөх олговрын гэрээний 5.4-р заалтын талаар асуудал тавьж ОТ ХХК -аас хариулт авсан
- 2004/2011 оны гэрээний талаар гомдолтой өрхийн дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж зуучлах багт өгсөн
- ОТ-ГС замын ус өнгөрүүлэх, мал болон ан амьтны гарам, замын гарцыг үзэж компанид мэдээлэл бэлтгэсэн
- ОТ нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл өгөх, малчдын оролцоог хангах талаар уулзалт зохион байгуулсан

Доорхи асуудлуудаар санал гаргаж харилцан тохиролцсон:

- Багуудын хүсэлтээр ОТ компанитай холбоотой тодорхой сэдвээр уулзалт зохион байгуулахад ОТ зүгээс бэлэн гэдгээ илэрхийлсэн
- Ундай гол, Бор Овоогийн Задгай, Халив-Дугатын гол гэсэн гурван чухал усны эх үүсвэрт Төслөөс учруулж буй нөлөөллүүдэд үнэлгээ хийж, тэдгээр нөлөөллүүд малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт ямар хохиролтой болохыг тогтоох, ялангуяа Оюу Толгой компаниас Ундай голын гольдролыг өөрчлөх, Бор овоогийн задгайг шилжүүлэх, хаягдал агуулах байгууламж, чулуун хаягдлын овоолгын нөлөөллүүдийн талаар өгсөн баримт мэдээлэл үнэн зөв эсэх, өөр хувилбар, өөрчлөлт байж болох эсэх, түүнчлэн малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт учрах нөлөөллүүдээс зайлсхийх буюу багасгах ямар нэмэлт арга хэмжээ авч болох тухайд үнэлгээ өгөх зорилго бүхий Хөндлөнгийн Шинжээчдээс бүрдсэн мэргэжлийн баг ажиллуулахаар харилцан тохиролцсон
- Хөндлөнгийн Шинжээчдийн багт тавигдах шалгуур, багийн ажлын даалгавар, тэдгээрийг сонгох үйл явцыг эцэслэн гаргаж, харилцан тохиролцсон
- Тоосны нөлөөллийг үнэлэх зорилгоор өвчилсөн малын эрхтэнийг Улсын төв лабораторт шинжлүүлэхэд ОТ зүгээс туслах
- ОТ төслийн талбай дотор Баруун болон зүүн өмнөд хэсэгт малын бэлчээр гаргаж, усны асуудлыг шийдэж өгөх тал дээр харилцан тохиролцсон

Дараагийн уулзалт 2013 оны 9 сарын 5-ны өдөр Ханбогд суманд болно.

Мэдээлэл бэлтгэсэн: Л.Батцэнгэл
Холбоо барих утас: 88705595, 99608279
Цахим хаяг: tsengel_5595@yahoo.com
Хишигдэлгэр, ОТ ХХК
Бат-Эрдэнэ, ОТ ХХК
Утас: 9902-9283
Утас: 9903-4723